



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2022/114/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.Umnugovi@audit.mn

Өмнөговь аймаг
Даланзадгад сум

2022 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Сүрэнжаргал

Утас: 70533552 Цахим хаяг: Surenjargald@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

46083, Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон 304 тоот
Утас: (976) 7053 3539, Вэб сайт: www.audit.mn
И-мэйл: umnugovi@audit.gov.mn

2022.02.15 № 35
танай _____ -ны № _____ -г

Г ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН
ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Д.МӨНХТУЛГА ТАНАА Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

018026040



Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЦЭРЭНБЯАР



Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

	Үзүүлэлт	/сая төгрөгөөр/ 2021.12.31
	Эргэлтийн хөрөнгийн дүн	16.7
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,593.5
	Нийт хөрөнгийн дүн	3,610.2
	Нийт өр төлбөрийн дүн	0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,610.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,610.2
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,762.0
	Үйл ажиллагааны зардлын дүн	3,106.4
	Үйл ажиллагааны үр дүн	-344.4
	Үйл ажиллагааны бус үр дүн	0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	0
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,954.6
	Тайлант оны үр дүн	-344.4
	Эцсийн үлдэгдэл	3,610.2
Мөнгөн гүйлгээний тайлан		
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,713.1
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,676.3
	Үйл ажиллагааны ЦМГ	36.8
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	36.8
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,154.7
	Урсгал зардал	2,154.7
	Хөрөнгийн зардал	0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	
	Улсын төсвөөс санхүүжих	2,154.7
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт хууль тогтоомжийг сахиулах, нийгмийн тогтвортой хөгжил, бизнес эрхлэх таатай орчинг дэмжих, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг



4	ТТЗ									
5	ТЕЗ									
НИЙТ		1	1					1		

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	1	38.1	0	0	0	0	0	0	1	38.1
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
НИЙТ		1	38.1	0	0	0	0	0	0	1	38.1